



ЖОДИ ПРОЖЕКТ ХХК-Д

**ЭРҮҮЛ МЭНДИЙН ЯАМ  
УЛСЫН АХЛАХ БАЙЦААГЧИЙН  
ДҮГНЭЛТ**

Засгийн газрын VIII байр, Олимпын гудамж 2,  
Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот 14210,  
Утас: 26-36-95, Факс: (976-11) 32-35-41,  
цахим шуудан: letter@moh.gov.mn,  
цахим хуудас: http://www.moh.mn

2024.04.26 № 10-00-02/005/125

**Зураг төсөлд эрүүл ахуйн  
хяналт хийсэн тухай**

Танай компаниас ирүүлсэн хүсэлтийн дагуу Монгол Улсын Эрүүл ахуйн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.3 дахь заалт, Барилгын тухай хуулийн 11.1.3, Засгийн газрын 2019 оны 108 дугаар тогтоолоор батлагдсан Барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах, магадлал хийх дүрмийн 5.1.2 дахь заалт, Эрүүл мэндийн салбарын хяналтын газрын даргын баталсан Барилга байгууламж барих газрын байршил тогтоох, зураг төсөл зохиох, ашиглалтад оруулахад эрүүл ахуйн урьдчилан сэргийлэх хяналт шалгалт хийх тухай 2024 оны 10-00/02 дугаартай удирдамжийг үндэслэн Архангай аймгийн Цэцэрлэг сумын нутаг дэвсгэрт төлөвлөгдөж буй "50 хүүхдийн цэцэрлэгийн барилга"-ын ажлын зураг төсөл, зурагт дагалдах баримт бичигт эрүүл ахуйн хяналт хийлээ.

Зураг төсөл боловсруулсан байгууллагын нэр, зураг төслийн нэр, үе шат:

Архангай аймгийн ерөнхий архитекторын баталсан 2024 оны 01 дүгээр сарын 29-ний өдрийн АТД-65-09/24 дугаартай архитектор төлөвлөлтийн даалгавар, Архангай аймгийн Засаг даргын баталсан 2024 оны 01 дүгээр сарын 22-ны өдрийн ЗД-2024/11 дугаартай "Архангай аймгийн Цэцэрлэг сумын Хүүхдийн цэцэрлэгийн барилгын ажлын зураг төсөл боловсруулах даалгавар, загвар зургийг үндэслэн ажлын зураг төслийг боловсруулсан байна.

Барилга архитектур, технологийн байгуулалт, барилга бүтээц, ерөнхий төлөвлөгөө, хүчит төхөөрөмж, дотор гэрэлтүүлэг, гадна цахилгаан, холбоо дохиолол, гадна дулаан, дулаан механик, халаалт, агаар сэлгэлт, ус хангамж ариутгах татуурга, цэвэр бохир усны ажлын зураг төслийг барилгын зураг төслийн "Жоди прожект" ХХК-д 2024 онд боловсруулсан. Ажлын зургийн шифр JP/24-01.

Барилга байгууламж барих газрын зөвшөөрөл:

Архангай аймгийн Цэцэрлэг сумын хүүхдийн цэцэрлэг (9000437 регистрийн дугаартай) сумын Засаг даргын 2019 оны 01 дүгээр сарын 11-ний өдрийн А/01 дугаартай захирамжийг үндэслэн Архангай аймгийн Цэцэрлэг сумын 5 дугаар баг, Дэнж-1 гудамж, 102 дугаартай хаягт байрлах, 6519000217 нэгж талбарын дугаартай, Боловсролын байгууллага зориулалтаар, 4584 м.кв газрыг 15 жилийн хугацаатай эзэмшүүлсэн, кадастрын зурагтай байна.

Зураг төслийн товч агуулга:

Төлөвлөж буй 50 хүүхдийн цэцэрлэгийн барилга нь тэнхлэгээрээ 21.0x14.4 хэмжээтэй, 2 давхар цутгамал төмөр бетон арагт бүтээцтэй. Барилгын нэгдүгээр давхарт гонх, коридор,

142524276

шатны хонгил, хувцас солих 2 өрөө, ариун цэврийн өрөө, гудас хураах 2 өрөө, аяга таваг угаах өрөөнүүд, анги 2 бүлэг байхаар, хоёрдугаар давхарт коридор, арга зүйчийн өрөө, багшийн өрөө, ажилчдын ариун цэврийн өрөө, аж ахуйн өрөө, биеийн тамирын танхим байхаар зураг төсөлд тусгагдсан байна.

Техникийн нөхцөл:

Ус хангамж, ариутгах татуурга: Ус хангамжийг цэцэрлэгийн гүний худгаас одоо байгаа барилгад оруулсан цэвэр усны оролтын шугамыг үргэлжлүүлэн дулаан шугамтай хамт татан уурын зуухны барилгад байрлах усан санд холбохоор, уурын зуухны барилгыг өргөтгөн 20 м<sup>3</sup> усны нөөцийн сав суурилуулахаар төлөвлөсөн. Барилгаас гарах ариутгах татуургыг бохир усны худагт холбохоор, бохир усыг 24 м<sup>3</sup> багтаамжтай бохирын цооногт өөрийн урсгалаар зайлуулахаар зургийн тайлбарт тусгасан байна.

Цахилгаан хангамж: “Эрдэнэт булганы цахилгаан түгээх сүлжээ” Төрийн өмчит хувьцаат компанийн Булган салбарын ахлах инженерийн баталсан 2024 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн №7/24 дугаартай техникийн нөхцөл гаргуулсан.

Холбоо мэдээлэл: Мэдээлэл холбооны сүлжээ ХХК-ийн Архангай аймгийн газрын даргын баталсан 2024 оны 01 дүгээр сарын 15-ны өдрийн А/02 дугаартай техникийн нөхцөлтэй.

Инженер геологийн судалгааны талаар: Архивын №20-017, ЗТП-550/19 дугаартай Энх-Өрнөлт ХХК-д хийгдсэн инженер геологийн судалгааны дүгнэлттэй. Барилгажих талбай нь газар чичирхийллийн 8 баллын бүсэд байрласан. Судалгаагаар инженер-геологийн дунд зэргийн нөхцөлтэй, хөрсний ус илрээгүй байна.

Дулаан хангамж: 50 хүүхдийн цэцэрлэгийн барилгыг бие даасан эх үүсвэртэй байхаар халаалтын зуухны барилга төлөвлөгдөж, холболтыг Ø45x2.5-н хос шугамаар барилга руу цэвэр усны хамт орохоор ажлын зургийн тайлбар бичигт тусгагдсан байна.

Дулаан хангамжийн эх үүсвэрт хатуу түлшний НЖР-25 маркийн нам даралтын хоёр зуух суурилуулахаар, халаалтын системд GRUNDFOS-ийн цахилгаан хөдөлгүүр бүхий хоолой дээр байрлуулдаг насосыг нөөцтэй байхаар, хүйтэн усны системд усны нөөцийн савны дараагаас өргөлтийн насос нөөцтэй тавихаар тус тус төлөвлөсөн байна.

Агаар сэлгэлт: Барилгын 1 дүгээр давхрын анги болон бусад өрөөнүүдэд агаар сорох ердийн систем, ангиудад хананаас агаар оруулах механик систем, 2 дугаар давхрын биеийн тамирын зааланд агаар оруулах болон сорох механик систем, давхар бүрийн ариун цэврийн өрөөнд агаар сорох механик систем байхаар зураг төсөлд тусгагдсан байна.

Эрүүл ахуйн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.3 дахь заалтыг үндэслэн ДҮГНЭХ НЬ:

1. Ус нөөцлөх савыг байрлуулахдаа ашиглалтын явцад угааж цэвэрлэх, халдваргүйжүүлэх үйл ажиллагаа явуулах боломжтой орон зайг усны нөөцийн савны эргэн тойронд болон дээд талд гаргаж өгөх.
2. Бохир усны цооногтой тохиолдолд хаягдал усыг тусгай зөвшөөрөл бүхий аж ахуйн нэгж, байгууллагатай гэрээ байгуулж, зайлуулах.
3. Цэцэрлэгийн барилгыг хөгжлийн бэрхшээлтэй иргэн (хүүхэд, насанд хүрсэн хүн)-ий хүртээмжтэй байдлыг БНБД 31-23-22-ын дагуу төлөвлөх.
4. Барилгын гадна, дотор засалд эрүүл ахуйн шаардлага хангасан, гарал үүсэл болон тохирлын гэрчилгээ бүхий барилгын материал сонгож хэрэглэх.

5. Архангай аймгийн Цэцэрлэг сумын нутаг дэвсгэрт төлөвлөгдөж буй “50 хүүхдийн цэцэрлэгийн барилга”-ын ажлын зураг төсөл төлөвлөлт нь “Сургуулийн өмнөх боловсролын байгууллагын сургалтын орчин. Ерөнхий шаардлага” MNS 6558:2015 стандарт, “Сургалт, хүмүүжлийн орчны эрүүл ахуйн шаардлага” MNS 6799:2019 стандарт, Барилга хот байгуулалтын сайдын 2022 оны 193-р тушаалаар батлагдсан “Сургуулийн өмнөх боловсролын байгууллагын барилгын төлөвлөлт норм, дүрэм”-д заасан эрүүл ахуйн шаардлагад нийцэж байна.

Улсын байцаагчийн гаргасан дүгнэлтийг үндэслэлгүй гэж үзвэл Монгол улсын Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1 дэх заалтыг үндэслэн гомдол гаргах эрхтэй.

ДҮГНЭЛТ ГАРГАСАН:

ЭРҮҮЛ АХУЙ, ХАЛДВАР ХАМГААЛЛЫН ХУЛАХ  
ХЯНАЛТЫН УЛСЫН АХЛАХ БАЙЦААГЧИЙН  
Н.НАНДИНЦЭЦЭГ



ТАНИЛЦАЖ ХҮЛЭЭН АВСАН:  
ЖОДИ ПРОЖЕКТ ХХК-ИЙН  
ТӨЛӨӨЛӨЛ